



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/141

Эрдэнэт

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5./а/, 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2017 оны 03 дугаар сарын 20-27-ны өдрүүдэд ӨМӨЗО-ны Улаан хотын 2 дугаар сургуультай хамтран ажиллах ажлын хүрээнд Боловсрол, соёл, урлагийн газрын ахлах мэргэжилтэн Дондовын Дашням сургалтанд хамрагдах тул зардалд нь 400000 /Дөрвөн зуун мянган/ төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2.Шаардагдах зардал 400000 /Дөрвөн зуун мянган/ төгрөгийг Засаг даргын нөөц сан хуваарилагдаагүй бусад зардлын жагсаалтын "Боловсрол, эрүүл мэнд, спорт, урлагийн салбарын ажиллагсдын мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх" арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү, Төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д. БАТЛУТ